



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Геронтологийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: САГ-2026/68/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим аяг:naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: В.Эрдэнэцогт Утас:261885 Цахим хаяг:erdenetsogtv@audit.gov.mn Аудитор: Ж.Бямбацогт Утас:260512 Цахим хаяг:Bayambatsogtj@audit.gov.mn Цэгцтөв богд аудит ХХК-ийн захирал:Н.Цэрэнханд Утас: 99901517 Цахим хаяг:tsegtstuvbogd@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	16
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	19
4.1 Ерөнхий зүйл .....	19
4.2 Материаллаг байдал .....	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	22
5.1 Төлбөрийн акт .....	22
5.2 Албан шаардлага.....	23
5.3 Зөвлөмж .....	24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	26

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ЭМДҮЗ	Эрүүл мэндийг дэмжих үндэсний зөвлөл



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ  
ТӨВИЙН ЗАХИРАЛ Д.БАТ-УНДРАХ  
ТАНАА

2026.02.25 № 06/441  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Хязгаарлалтай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Геронтологийн үндэсний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 89,525.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Бусад хангамжийн материалын болон эмийн зарлагыг хүчин төгөлдөр бус, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 82,009.9 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн;
- Жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг журам, зааврын дагуу иж бүрэн, үнэн зөв тайлагнаагүй, хугацаа хоцроож ирүүлсэн.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5, 20.1.4, Төрийн хэмнэлтийн хуулийн 6.1 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд Эрүүл мэндийн яам, Геронтологийн үндэсний төв хамтран Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр 2025 оны 10 дугаар сарын 06-нд “Эрүүл, идэвхтэй насжилт-2025” үндэсний зөвлөлгөөнийг 18,455.2 мянган төгрөгөөр зохион байгуулж, Монгол улсын настны тусламж, үйлчилгээг хөгжүүлэх үндсэн чиглэл, баримт бичгийг тодорхойлж, зөвлөмж гаргасан байна.

## **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд нээлттэй тендер сонгон шалгаруултын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 166,000.0 мянган төгрөгийн эмнэлэгийн тоног төхөрөмж, 119,442.4 мянган төгрөгийн оффисын тоног төхөөрөмж худалдан авснаар 34,856.6 мянган төгрөгийн тендерийн хэмнэлт гарсан байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Геронтологийн үндэсний төвийн захирлын тушаалаар бүтцийн өөрчлөлт хийж ахлах нягтлан бодогчийг ажлаас чөлөөлж, санхүү бүртгэл дэмжих үйлчилгээний албаны даргад нягтлан бодогчийн ажлыг хариуцуулан хийлгэсэн бөгөөд аудитын хугацаанд байгууллагын санхүү төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх албан тушаалтан тогтвор суурьшилтай ажиллахгүй байгаа нь үүрэг, хариуцлагын тогтолцоо, дотоод хяналтын орчинд сөргөөр нөлөөлж байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



*[Handwritten signature]*

Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>348,551,224.03</b>	<b>287,456,410.26</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>17,248,880.31</b>	<b>104,448,139.01</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	17,248,880.31	104,448,139.01
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	17,248,880.31	104,448,139.01
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	17,248,880.31	104,448,139.01
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>158,427,173.80</b>	<b>3,857,892.94</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	818,875.93
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	158,427,173.80	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	3,039,017.01
3351	Байгууллагаас авах авлага	-	3,039,017.01
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>172,875,169.92</b>	<b>179,150,378.31</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	42,661,781.95	40,168,179.94
35110	Тусгай зориулалттай материал	80,000.00	80,000.00
35130	Эм боох материал	42,581,781.95	40,088,179.94
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	130,213,387.97	138,982,198.37
35410	Бичиг хэргийн материал	472,290.00	261,600.00
35420	Аж ахуйн материал	17,401,904.00	18,480,221.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,140,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал	967,013.20	641,316.60
35470	Бусад хангамжийн материал	110,232,180.77	119,599,060.77
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,382,557,735.93</b>	<b>1,561,988,625.71</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,382,557,735.93</b>	<b>1,561,988,625.71</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,305,593,903.55	1,485,122,793.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	125,920,677.50	125,920,677.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	(102,178,417.92)	(106,184,813.36)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	168,000,000.00	168,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(25,400,589.05)	(32,000,589.05)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,290,928,653.13	1,530,926,065.73
39206	Хуримтлагдсан элэгдэл	(395,907,593.70)	(453,763,084.40)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	287,858,486.00	305,949,140.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(43,627,312.41)	(53,724,603.13)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	76,963,832.38	76,865,832.42
39301	Програм хангамж	1,470,000.00	1,470,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(958,999.62)	(1,056,999.58)
39303	Бусад биет бус хөрөнгө	76,452,832.00	76,452,832.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,731,108,959.96</b>	<b>1,849,445,035.97</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>86,289,247.83</b>	<b>18,050,545.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	86,289,247.83	18,050,545.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>86,289,247.83</b>	<b>18,050,545.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,286,247.83	130,695.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,187,850.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	84,003,000.00	16,732,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	84,003,000.00	16,732,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,644,819,712.13</b>	<b>1,831,394,490.97</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,644,819,712.13	1,831,394,490.97
51100	Засгийн газрын оруулсан капитал	478,903,308.00	478,903,308.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	478,903,308.00	478,903,308.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,036,418,100.46</b>	<b>1,222,992,879.30</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	696,608,613.73	1,036,418,100.46
51220	Тайлант үеийн үр дүн	339,809,486.73	186,574,778.84
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	129,498,303.67	129,498,303.67
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>1,731,108,959.96</b>	<b>1,849,445,035.97</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2,708,223,344.11</b>	<b>2,646,692,708.77</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>224,560,680.11</b>	<b>3,628,756.77</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	224,560,680.11	3,628,756.77
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	439,116.00	1,964,412.77
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	439,116.00	1,964,412.77
120009	Бусад орлого	630,000.00	-
120017	Үнэ төлбөргүй орлого /Үндсэн хөрөнгө/	223,059,177.71	-
120018	Үнэ төлбөргүй орлого /Бараа материал/	432,386.40	1,664,344.00
<b>122</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,484,292,664.00</b>	<b>2,643,063,952.00</b>
<b>12211</b>	<b>Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт</b>	<b>1,854,758,466.00</b>	<b>1,968,526,272.00</b>
122111	Урсгал санхүүжилтийн орлого	1,854,758,466.00	1,968,526,272.00
<b>12213</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>629,534,198.00</b>	<b>674,537,680.00</b>
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	12,615,596.00	79,769,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,449,428.00	12,824,240.00
122136	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	603,469,174.00	581,944,440.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,369,043,857.38</b>	<b>2,459,681,160.10</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,369,043,857.38</b>	<b>2,459,681,160.10</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,910,115,086.51</b>	<b>2,226,545,397.17</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,355,276,275.47</b>	<b>1,628,137,936.08</b>
210101	Үндсэн цалин	821,756,991.27	964,615,939.45
210102	Нэмэгдэл	171,226,452.20	264,535,651.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	105,522,000.00	154,488,000.00
210104	Урамшуулал	256,770,832.00	244,498,345.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>159,161,652.77</b>	<b>192,091,925.16</b>
210201	Тэтгэврийн даатгал	109,685,525.66	131,333,742.93
210202	Тэтгэмжийн даатгал	13,832,630.63	16,746,342.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,156,123.79	8,678,621.84
210204	Ажилгүйдлийн даатгал	5,592,493.12	7,024,644.11
210205	Эрүүл мэндийн даатгал	22,894,879.57	28,308,573.87
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>72,109,807.68</b>	<b>69,729,640.40</b>
210301	Гэрэл, цахилгаан	7,200,522.45	10,067,577.42
210302	Түлш, халаалт	2,874,228.70	4,001,638.19
210303	Цэвэр, бохир ус	3,015,894.53	2,279,494.79
210304	Байрны түрээс	59,019,162.00	53,380,930.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>32,145,123.04</b>	<b>34,014,528.63</b>
210401	Бичиг хэрэг	3,543,606.00	4,563,485.00
210402	Тээвэр, шатахуун	8,765,780.94	6,911,176.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,521,655.20	7,684,133.03
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,400,000.00	3,750,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,914,080.90	11,105,734.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>41,071,739.70</b>	<b>24,731,746.51</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	37,322,639.70	20,506,746.51
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,749,100.00	4,225,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,487,400.00</b>	<b>19,185,750.00</b>
210604	Урсгал засвар	10,487,400.00	19,185,750.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,000,000.00</b>	<b>38,807,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,000,000.00	38,807,200.00

Геронтологийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>35,825,838.00</b>	<b>94,909,176.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,973,650.00	78,059,277.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,139,700.00	820,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	228,916.00	832,456.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,651,800.00	7,336,000.00
210807	Газрын төлбөр	1,421,062.00	1,912,693.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,410,710.00	948,750.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>199,037,249.85</b>	<b>124,937,494.39</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,747,366.75	2,459,754.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	190,289,883.10	122,477,740.39
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>458,928,770.87</b>	<b>233,135,762.93</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>416,908,405.15</b>	<b>129,292,162.09</b>
<b>21311</b>	<b>Засгийн газрын дотоод шилжүүлэг</b>	<b>416,908,405.15</b>	<b>129,292,162.09</b>
<b>213112</b>	Төсөвт байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлэгийн зардал	416,908,405.15	129,292,162.09
<b>2131121</b>	Санжүүжилтийн үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлэгийн зардал	416,908,405.15	129,292,162.09
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>42,020,365.72</b>	<b>103,843,600.84</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,890,365.72	83,493,600.84
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,130,000.00	20,350,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3=1-2)</b>	<b>339,179,486.73</b>	<b>187,011,548.67</b>
<b>5</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРЛАГЫН ДҮН</b>		<b>436,769.83</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсны гарз	00.00	436,769.83
<b>7</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (5=4-5)</b>	00.00	(436,769.83)
<b>6</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (6=3+7)</b>	<b>339,179,486.73</b>	<b>186,574,778.84</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>2,418,629,570.20</u></b>	<b><u>2,805,527,125.57</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>2,802,191,125.80</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	<b>3,335,999.77</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	-	<b>3,335,999.77</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		143,999.77
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,192,000.00
<b>122</b>	<b>ТУСЛАМЖИЙН ОРЛОГО</b>	<b>2,418,629,570.20</b>	<b>2,802,191,125.80</b>
<b>1221</b>	<b>Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлэгийн орлого</b>	<b>1,854,758,466.00</b>	<b>1,968,526,272.00</b>
12211	Урсгал санхүүжилтийн орлого	1,854,758,466.00	1,968,526,272.00
<b>12213</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>563,871,104.20</b>	<b>833,664,853.80</b>
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	12,615,596.00	79,769,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,449,428.00	13,524,240.00
122136	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	537,806,080.20	740,371,613.80
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,167,889,718.79</b>	<b>2,415,302,466.87</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,167,889,718.79</b>	<b>2,415,302,466.87</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,708,960,947.92</b>	<b>2,182,156,703.94</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,349,564,610.62</b>	<b>1,631,162,214.42</b>
210101	Үндсэн цалин	800,325,698.43	929,917,056.28
210102	Нэмэгдэл	170,868,596.18	304,992,936.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	98,741,357.50	152,511,422.06
210104	Урамшуулал	279,628,958.51	243,740,799.11
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>160,794,226.62</b>	<b>191,360,979.59</b>
210201	Тэтгэврийн даатгал	113,746,539.00	130,602,797.36
210202	Тэтгэмжийн даатгал	13,172,026.59	16,746,342.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,809,628.85	8,678,621.84
210204	Ажилгүйдлийн даатгал	5,311,825.57	7,024,644.11
210205	Эрүүл мэндийн даатгал	21,754,206.61	28,308,573.87
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>68,587,098.25</b>	<b>69,496,515.84</b>
210301	Гэрэл, цахилгаан	7,200,522.45	10,067,577.42
210302	Түлш, халаалт	2,874,228.70	4,001,638.19
210303	Цэвэр, бохир ус	3,015,894.53	2,046,370.23
210304	Байрны түрээс	55,496,452.57	53,380,930.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,216,751.40</b>	<b>35,140,340.59</b>
210401	Бичиг хэрэг	2,676,700.00	3,705,600.00
210402	Тээвэр, шатахуун	6,844,400.00	7,866,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,521,655.40	7,917,257.59
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,664,000.00	3,750,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,509,996.00	11,900,983.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>16,619,695.00</b>	<b>23,607,750.50</b>

**Геронтологийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,994,495.00	18,793,350.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,625,200.00	4,814,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>35,735,006.40</b>	<b>90,057,320.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,749,300.00	70,396,000.00
210602	Тавилга	18,006,806.40	1,008,970.00
210604	Урсгал засвар	11,978,900.00	18,652,350.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,000,000.00</b>	<b>37,991,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,000,000.00	37,991,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>38,524,233.43</b>	<b>60,191,968.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,765,305.43	42,868,819.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,139,700.00	820,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	178,916.00	832,456.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,248,050.00	7,336,000.00
210807	Газрын төлбөр	1,421,062.00	1,912,693.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	721,200.00	1,422,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,919,326.20</b>	<b>43,148,415.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,919,326.20	3,288,415.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	39,860,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>458,928,770.87</b>	<b>233,145,762.93</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>416,908,405.15</b>	<b>129,292,162.09</b>
<b>21311</b>	<b>Засгийн газрын дотоод шилжүүлэг</b>	<b>416,908,405.15</b>	<b>129,292,162.09</b>
<b>213112</b>	Төсөвт байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлэгийн зардал	416,908,405.15	129,292,162.09
<b>2131121</b>	Санжүүжилтийн үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлэгийн зардал	416,908,405.15	129,292,162.09
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>42,020,365.72</b>	<b>103,853,600.84</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,890,365.72	83,493,600.84
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,130,000.00	20,360,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>250,739,851.41</u></b>	<b><u>390,224,658.70</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>543,133,381.60</b>	<b>303,025,400.00</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	543,133,381.60	303,025,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	543,133,381.60	303,025,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	543,133,381.60	303,025,400.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(543,133,381.60)</u></b>	<b><u>(303,025,400.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+7</b>	<b>(292,393,530.19)</b>	<b>87,199,258.70</b>
<b>101</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	309,642,410.50	17,248,880.31
<b>20</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	17,248,880.31	104,448,139.01

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	478,903,308.00	129,498,303.67	696,608,613.73	1,305,010,225.40
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	478,903,308.00	129,498,303.67	696,608,613.73	1,305,010,225.40
9	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	339,179,486.73	339,179,486.73
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	478,903,308.00	129,498,303.67	1,036,418,100.46	1,644,819,712.13
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	478,903,308.00	129,498,303.67	1,036,418,100.46	1,644,819,712.13
19	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	186,574,778.84	186,574,778.84
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	478,903,308.00	129,498,303.67	1,222,992,879.30	1,831,394,490.97

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
<b>I</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>1,984,261,100.00</b>	<b>1,842,570,109.68</b>	<b>136,211,790.32</b>	<b>92.9</b>
<b>12</b>	<b>Татварын бус орлого</b>	<b>1,984,261,100.00</b>	<b>1,842,570,109.68</b>	<b>136,211,790.32</b>	<b>92.9</b>
120	Нийтлэг татварын бус орлого	5,479,200.00	3,335,999.77	2,143,200.23	-
120004	Төсвийн байгууллагын өөрийн орлого /үндсэн/	-	143,999.77	(143,999.77)	-
120010	Төсвийн байгууллагын өөрийн орлого /туслах/	5,479,200.00	3,192,000.00	2,287,200.00	58.3
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>1,978,781,900.00</b>	<b>1,839,234,109.91</b>	<b>139,547,790.09</b>	<b>92.9</b>
122005	Төсвөөс санхүүжих	1,978,781,900.00	1,839,234,109.91	139,547,790.09	92.9
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,984,261,100.00</b>	<b>1,842,570,109.68</b>	<b>141,690,990.32</b>	<b>92.9</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,984,261,100.00</b>	<b>1,842,570,109.68</b>	<b>141,690,990.32</b>	<b>92.9</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,886,517,900.00</b>	<b>1,759,076,508.84</b>	<b>127,441,391.16</b>	<b>93.2</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,668,061,200.00</b>	<b>1,568,020,891.42</b>	<b>100,040,308.58</b>	<b>94.0</b>
210101	Үндсэн цалин	858,608,900.00	929,917,056.28	(71,308,156.28)	108.3
210102	Нэмэгдэл	495,106,500.00	304,992,936.97	190,113,563.03	61.6
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	167,374,400.00	152,511,422.06	14,862,977.94	91.1
210104	Урамшуулал	146,971,400.00	180,599,476.11	(33,628,076.11)	122.9
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>210,831,900.00</b>	<b>184,218,204.38</b>	<b>26,613,695.62</b>	<b>87.4</b>
210201	Тэтгэврийн даатгал	143,373,500.00	125,769,874.75	17,603,625.25	87.7
210202	Тэтгэмжийн даатгал	16,904,900.00	16,114,929.18	789,970.82	95.3
210203	ҮОМШӨ ний даатгал	8,459,500.00	8,340,805.30	118,694.70	98.6
210204	Ажилгүйдлийн даатгал	8,416,700.00	6,756,519.54	1,660,180.46	80.3
210205	Эрүүл мэндийн даатгал	33,677,300.00	27,236,075.61	6,441,224.39	80.9
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>4,334,000.00</b>	<b>3,548,998.04</b>	<b>785,001.96</b>	<b>81.9</b>
210301	Гэрэл цахилгаан	2,841,700.00	3,162,679.36	(320,979.36)	111.3
210302	Түлш, халаалт	626,400.00	245,800.00	380,600.00	39.2
210303	Цэвэр, бохир ус	865,900.00	140,518.68	725,381.32	16.2
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,290,800.00</b>	<b>3,288,415.00</b>	<b>2,385.00</b>	<b>99.9</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,290,800.00	3,288,415.00	2,385.00	99.9
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>97,743,200.00</b>	<b>83,493,600.84</b>	<b>14,249,599.16</b>	<b>85.4</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	97,743,200.00	83,493,600.84	14,249,599.16	85.4
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	97,743,200.00	83,493,600.84	14,249,599.16	85.4
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>47</b>	<b>44</b>	<b>3</b>	<b>93.6</b>
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	37	36	1	97.3
620003	Үйлчлэх ажилтан	9	7	2	77.8

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
1	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>788,179,600.00</b>	<b>833,664,853.80</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>788,179,600.00</b>	<b>833,664,853.80</b>
122	<b>Тусламжийн орлого</b>	<b>788,179,600.00</b>	<b>833,664,853.80</b>
1221	Хандив тусламж//дотоод/	788,179,600.00	833,664,853.80
12213	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>788,179,600.00</b>	<b>833,664,853.80</b>
122132	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	79,769,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,800,700.00	13,524,240.00
122136	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	778,378,900.00	740,371,613.80
2	<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>788,179,600.00</b>	<b>746,465,595.10</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>788,179,600.00</b>	<b>746,465,595.10</b>
210	<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>768,179,600.00</b>	<b>726,105,595.10</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	65,000,000.00	63,141,323.00
210104	Урамшуулал	65,000,000.00	63,141,323.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>8,125,000.00</b>	<b>7,142,775.21</b>
210201	Тэтгэврийн даатгал	5,525,000.00	4,832,922.61
210202	Тэтгэмжийн даатгал	520,000.00	631,413.23
210203	ҮОМШӨ ний даатгал	650,000.00	337,816.54
210204	Ажилгүйдлийн даатгал	130,000.00	268,124.57
210205	Эрүүл мэндийн даатгал	1,300,000.00	1,072,498.26
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>76,320,100.00</b>	<b>65,947,517.80</b>
210301	Гэрэл цахилгаан	7,440,000.00	6,904,898.06
210302	Түлш, халаалт	4,780,500.00	3,755,838.19
210303	Цэвэр, бохир ус	1,899,600.00	1,905,851.55
210304	Байрны түрээс	62,200,000.00	53,380,930.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>35,254,300.00</b>	<b>35,140,340.59</b>
210401	Бичиг хэрэг	3,435,600.00	3,705,600.00
210402	Тээвэр (шатахуун)	6,357,000.00	7,866,500.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	8,316,400.00	7,917,257.59
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,000,000.00	3,750,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	14,145,300.00	11,900,983.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>23,614,400.00</b>	<b>23,607,750.50</b>
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	18,800,000.00	18,793,350.50
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	4,814,400.00	4,814,400.00
2106	<b>Эд хогшил худалдан авах</b>	<b>466,302,200.00</b>	<b>393,082,720.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	404,302,200.00	355,485,400.00
210602	Тавилга	19,000,000.00	18,944,970.00
210604	Урсгал засвар	43,000,000.00	18,652,350.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>11,470,800.00</b>	<b>37,991,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	11,470,800.00	37,991,200.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	<b>82,092,800.00</b>	<b>60,191,968.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,900,000.00	42,868,819.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	5,000,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	820,000.00	820,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	832,400.00	832,456.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	80,000.00	-
210806	Мэдээллийн технологийн зардал	10,038,400.00	7,336,000.00
210807	Газрын төлбөр	2,000,000.00	1,912,693.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,422,000.00	1,422,000.00
2201	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>-</b>	<b>39,860,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	39,860,000.00

**Геронтологийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>20,000,000.00</b>	<b>20,360,000.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,000,000.00	20,360,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	20,000,000.00	20,360,000.00
<b>4</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>		(87,199,258.70)
<b>5</b>	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		(87,199,258.70)
<b>6</b>	<b>Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>		<b>(87,199,258.70)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	<b>17,248,880.31</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	<b>104,448,139.01</b>

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Геронтологийн үндэсний төв нь эрхэм зорилгоо “Монгол хүний эрүүл, идэвхтэй насжилтад нөлөөлөх хүчин зүйлсийг судалж, настанд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэх замаар үйлчлүүлэгчийг дээдэлсэн, мэргэшсэн хамт олныг бүрдүүлэхэд оршино” гэж тодорхойлсон.

Геронтологийн үндэсний төв нь насжилт, настны эмгэг судлалын чиглэлээр улсын хэмжээнд лавлагаа шатлалын мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт зохион байгуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тус төв нь төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, хөтөлбөрийг үндэсний түвшинд хэрэгжүүлэх, шинжлэх ухаан технологийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд оролцох, ахмад настны эрүүл мэндийг тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Геронтологийн үндэсний төв нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, Ахмад настны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн актуудад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайланд онд үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын хууль;
- Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 25-ны 238 тоот тогтоол "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай";
- Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/321 дугаар тушаалаар Геронтологийн үндэсний төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсан;
- ЭМДҮЗ-ийн 2025 оны 03 дугаар тогтоол "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай";
- ЭМДҮЗ-ийн 2025 оны 04 дүгээр тогтоол "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай";
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үнэллээ.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Геронтологийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус төвийн захирлын 2021 оны А/73 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа боловч бодлогын баримт бичиг нь 2021 оноос хойш өөрчлөлт ороогүй, салбарын үйл ажиллагааг зохицуулсан хууль, дүрэм журмын онцлогийг нарийвчлан тусгаагүй, үйл ажиллагааны онцлогт нийцээгүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Геронтологийн үндэсний төв нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 118,336.0 мянган төгрөгөөр буюу 6.8 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	17,248.9	104,448.1	87,199.2
Авлага	158,427.2	3,857.9	(154,569.3)
Бараа материал	172,875.2	179,150.4	5,275.2
Үндсэн хөрөнгө	1,382,557.7	1,561,988.6	179,430.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,731,109.0</b>	<b>1,849,445.0</b>	<b>118,336.0</b>
Өр төлбөр	86,289.3	18,050.5	(68,238.8)
Засгийн газрын оролцоо/ Эздийн өмч/	1,644,819.7	1,831,394.5	186,574.8
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,731,109.0</b>	<b>1,849,445.0</b>	<b>118,336.0</b>

Тайлант онд мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данстуудад материаллаг дүнтэй өөрчлөлт гарсан байна. Үүнд

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 104,448.1 мянган төгрөг нь эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн үлдэгдэл байна;

Авлага дансны үлдэгдэл 3,587.9 мянган төгрөг болж, 154,569.3 мянган төгрөгөөр буурахад эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн авлага 158,427.2 мянган төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна. Нийт авлагын үлдэгдлийн 78.8 хувь буюу 3,039.0 мянган төгрөг нь бусад байгууллагаас авах шатахууны авлага байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 179,430.9 мянган төгрөгөөр өссөн нь худалдаж авсан 302,025.4 мянган төгрөг, бусад байгууллагаас шилжүүлэн авсан 320.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2025 оны 451 дугаар “ Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” тогтоолоор акталсан хөрөнгө

44,257.3 мянган төгрөг, 78,657.1 мянган төгрөгийн элэгдлийн дүнгээр буурсан үзүүлэлтэй байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 68,238.8 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны худалдаж авсан тоног төхөөрөмжийн баталгаат хугацааны барьцаа 67,271.0 мянган төгрөгийг чөлөөлсөн, ажиллагчидтай холбогдсон өглөгийг 2,155.6 мянган төгрөг барагдуулж, бусад бараа үйлчилгээний зардлын өглөг 1,187.8 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо /ээдийн өмч/ 186,574.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн дүнгээр нэмэгдсэн байна.

#### Программ хангамжийн талаарх судалгааны үр дүн:

Тус төв 1,470.0 мянган төгрөгийн 3 төрлийн программ ашигладаг. Тайлант онд эмнэлгийн тусламж үйлчилгээний зориулалтай “E-health” программын хөгжүүлэлтэд 6,960.0 мянган төгрөг, албан бичиг хэрэг хөтлөлт, хүний нөөцийн “Able ERP” программын хөгжүүлэлтэд 5,389.0 мянган төгрөг, нягтлан бодох бүртгэлийн “Acolous 2025” программын хөгжүүлэлтэд 792.0 мянган төгрөг, нийт 13,141.0 мянган төгрөг зарцуулсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,832,200.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн саналаас 160,500.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 1,992,700.0 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнээс улсын төсвөөс 1,987,220.8 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 5,479.2 мянган төгрөгөөр эх үүсвэр бүрдүүлэхээр баталсан.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор цалинг 6.0 хувь нэмэгдүүлэн 2025 оны 01 сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлэхээр шийдвэр гарснаас шалтгаалсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 8,438.9 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,978,781.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 5,479.2 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,968,526.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 3,336.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,842,570.1 мянган төгрөг зарцуулж, үлдэгдэл 129,292.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,842,570.1 мянган төгрөг буюу 92.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 100,040.3 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 26,613.7 мянган төгрөг, байр ашиглалтай холбоотой тогтмол зардлыг 785.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг

2.3 мянган төгрөг, урсгал шилжүүлгийг 14,249.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
1	71602-Эмнэлгийн тусламж үйлчилгээ	1,984,261.1	1,842,570.1	141,691.0	92.9
2	80101-Үндсэн үйл ажиллагааны дүн	1,883,227.1	1,755,788.1	127,439.0	93.2
3	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	97,743.2	83,493.6	14,249.6	85.4
4	83112-Хөтөлбөр төслийн дотоод урсгал	3,290.8	3,288.4	2.4	99.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

*1. Байгууллагуудын орон тооны цомхотголын талаар:*

Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/321 дугаар тушаалаар тус төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг баталж, 47 орон тоотой үйл ажиллагаа явуулахаар болсон байна. Үүний дагуу чиг үүргийн давхардлыг арилгах, нэгтгэх, зарим үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх зэргээр захиргааны бүтцийг цомхон болгох, зохицуулалтыг захирлын 2025 оны А/74 дүгээр тушаалаар хийж, орон тоогоо 9 хувиар бууруулсан байна. Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 1,631,162.2 мянган төгрөгөөр баталж, 1,568,020.9 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

*2. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар:*

Нэг хүнд ногдох 1 өдрийн хоолны зардал 16.0 мянган төгрөг, унааны зардал 2.0 мянган төгрөг байхаар захирлын 2025 оны 05 дүгээр сарын 28-ний өдрийн А/43 дугаар тушаалаар баталсан байна. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын төсвийг 167.4 мянган төгрөгөөр баталж, 152.5 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

*3. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүн:*

Тус төвийн захирлын 2025 оны 04 дүгээр сарын 15-ны А/ 29 дүгээр тушаалаар 4 удаагийн Настны эрүүл мэнд цогц үнэлгээ багц цагийн сургалт орон нутагт хийхээр 8,723.3 мянган төгрөгийн төсөв батлагдаж, 8,723.3 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

4. Гадаад томилолт, арга хэмжээ болон хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээ, шүүхийн шийдвэрийг нөхөн төлүүлсэн зардал тайлант онд гараагүй байна.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 788,179.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 9,800.7 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр баталснаас, гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 740,371.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоор 13,524.2 мянган төгрөгийг бүрдүүлж

нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн, мөн Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 79,769.0 мянган төгрөгийн санхүүжилт орж, нийт 833,664.9 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал зардалд 746,465.6 мянган төгрөг зарцуулсан байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээс “Эрүүл насжилт 2025 оны үндэсний зөвлөгөөн”-д 18,470.0 мянган төгрөг, “Ахмад настны эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээ” сургалтыг 9 аймаг, 6 дүүрэгт зохион байгуулж, 61,299.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Геронтологийн үндэсний төв нь 2025 онд 385,833.0 мянган төгрөгийн бараа худалдан авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 346,780.7 мянган төгрөг зарцуулсан байна. Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болон шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг байршуулсан байна.

/мянган төгрөгөөр/

д/д	Худалдан авалтын нэр	Худалдан авах арга	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт+, хэтрэлт -
1	Эмнэлгийн тоног төхөөрөмж, тавилга	Нээлттэй тендер шалгаруулалт	320,299.2	285,442.4	34,856.8
2	Эм, эмнэлгийн хэрэгсэл	Ерөнхий гэрээ	7,000.0	6,961.9	38.1
3	Бусад бараа	Шууд худалдан авах	58,533.8	54,376.4	4,157.4
4	дүн		385,833.0	346,780.7	39,052.3

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Геронтологийн үндэсний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Геронтологийн үндэсний төв, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бараа материал, эмийн тайлангийн анхан шатны бүртгэлийн баримт бүрдүүлэлт, цалин болон нэмэгдэл хөлс, урамшуулал, төсвийг зохистой удирдаж, өр, авлага үүсгэхгүй байх, төсвийн орлого, зарлагын ангиллыг зөв мөрдөх, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Цэгцтөв богд аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Өлзий-Орших, туслах аудитор П.Пунцаг нар гүйцэтгэж, аудитын менежер Т.Энхцэцэг, захирал Н.Цэрэнханд нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер В.Эрдэнэцогт, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Геронтологийн үндэсний төв нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дүгээр сарын 02-ны өдрийн 33 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардал 2,369,043.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож 23,690.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй, цалингийн давхардлыг арилгах, цахим дэлгүүрт байршсан эм эмнэлгийн хэрэгслээс худалдан авалт хийх, албан томилолт, байрны түрээсийн зардлыг хэмнэх зэрэг арга хэмжээний үр дүнд 129,292.2 мянган төгрөгийг дутуу зарцуулж, төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн

асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус төв нь шилэн дансны цахим хуудаст 139 мэдээлэл байршуулахаас 47 мэдээллийг хугацаа хоцроож, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 391,954.4 мянган төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй байна. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулбал зохих мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хуульд заасан хугацаанаас 8 хоногоор хоцроож аудитын байгууллагад ирүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд ирүүлээгүй зөрчил гаргасан албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, авлага, цалин хөлс, түрээсийн гэрээ, худалдан авах ажиллагааны хувьд горим, сорил хэрэгжүүллээ.

Завсрын аудитаар 612,503.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 527,855.9 мянган төгрөгийн 4 залруулга, 18,094.9 мянган төгрөгийн 3 зөвлөмж, 66,552.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлэхээр шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Жилийн эцэст дахин хянаж хэрэгжээгүй 1 зөвлөмжид албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

#### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар 1,013,475.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 6,727.4 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 1,006,748.4 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөнөөс шийдвэрийн хэрэгжилт 76.1 хувьтай байна.

Хүснэгт 4: Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	-	2		99.0
Албан шаардлага	5	1,006,748.4	3	615,942.3	75.8
Төлбөрийн акт	3	6,727.4	2	2,827.0	53.6
<b>Нийт дүн</b>	<b>10</b>	<b>1,013,475.8</b>	<b>9</b>	<b>618,769.3</b>	<b>76.1</b>

Өмнөх онд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг бүрэн байршуулаагүй зөрчил давтагдсан тул хариуцлага тооцох албан шаардлага өгч, мөн 1 албан шаардлагын зөрчил давтагдсанд дараагийн шийдлийг сонгож төлбөрийн акт тогтоосон, 2 төлбөрийн акт бүрэн бараагүй байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-г бүрэн хэрэгжүүлж байгааг шалгах.
2. Өмнөх онд худалдаж авсан бэлтгэн нийлүүлэгч байгууллагын агуулахад байгаа 647,485.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг тус төвийн барилгыг ашиглалтад хүлээж авсны дараа бүрэн суурилуулж, ашиглаж байгаа эсэхийг дараагийн аудитаар анхаарах шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 102,114.6 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

*Залруулсан алдаа:*

- Петростар ХХК-д түлш шатахууны зардлаас 3,019.7 мянган төгрөг шилжүүлж, тохируулах бичилтээр шууд зардалд бүртгэсэн;
- Бараа материалын дансны үлдэгдлийг 30.1 мянган төгрөгөөр дутуу, 538.2 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
- Акталсан үлдэх өртөгтэй 360.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассаны гарзыг тайлант үеийн элэгдлийн зардлаар бүртгэсэн;
- Байгууллагад төлөх өглөгийг 2,772.0 мянган төгрөгөөр, хувь хүмүүст төлөх өглөгийг 120.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
- Тайлант үеийн үр дүнг 577.2 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
- Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих дүнг 120.0 мянган төгрөгөөр дутуу, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг 5,772.0 мянган төгрөгөөр илүү, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын хандив 79,769.0 мянган төгрөгийг эдийн засгийн ангилал зөрүүлж, тайлагнасан;
- Үр дүнгийн тайланд зардлын эдийн засгийн ангилалыг 6,085.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Мөнгөн гүйлгээний тайланд туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих дүнг 2,994.0 мянган төгрөгөөр дутуу, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг 2,994.0 мянган төгрөгөөр илүү тусгасан.

Энэ нь УСНББОУС-1-ийн 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг” гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй.

Аудитаар нийт 89,525.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 4,364.7 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 83,452.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 1,707.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 89,525.3 мянган төгрөгийн залруулаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түшингээс 65,834.9 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

1. Хөрөнгийн үнэлгээний төлбөр 188.6 мянган төгрөгийг ДАМНО ХХК-д анхан шатны нотлох баримтгүй шилжүүлсэн байна. Энэ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Шийдвэрлэсэн нь: ДАМНО ХХК-аар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Тус төвийн захирлын 2025 оны А/33 дүгээр тушаалаар сахилгын шийтгэл ногдуулж, сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад эдийн засагчид үр дүнгийн мөнгөн урамшуулалд 2,720.2 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-д "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.7-д "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон мөнгөн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Тус төвийн захирал нь хот дотор албан тушаалын суудлын автомашин хэрэглэж 773.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулж, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй. Мөн анхан шатны баримтгүй 682.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.1."Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтгүй зарцуулсан шатахууны зардлыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

## **5.2 Албан шаардлага**

1. Бусад хангамжийн материалын тайлангийн орлого, зарлагын гарын үсгийн бүрдэл дутуу хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар 65,446.9 мянган төгрөг, эмийн тайлангийн баримтыг хянаж, зөвшөөрсөн эмнэлгийн тусламж, үйлчилгээний албаны даргын зөвшөөрөлгүй, эмчлүүлэгчийн хэрэглэсэн эмийн жагсаалтыг хавсаргаагүй 16,563.0 мянган төгрөгийн анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэдэг зөрчлийг таслан зогсоох, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Тус төвийн захирлын 2025 оны А/34 дүгээр тушаалаар ахлах нягтлан бодогчид цалинг 3 сарын хугацаатай 20 хувь бууруулах сахилгын шийтгэл оногдуулсны 1,081.2 мянган төгрөг, сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад 2 дугаар улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалд 361.7 мянган төгрөг тус тус олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1-д "Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно", 119.1.3-т "ажилтанд энэ хуулийн 123.2.3-т заасан хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулсан", мөн хуулийн 123 дугаар зүйлийн 123.8 "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралтаар баталсан", Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.7-д "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэлийг дутуу суутгасан болон сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад, урамшуулал олгосон зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### *1. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой асуудал:*

2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан журам, зааврын дагуу тодруулга болон Төсвийн тухай хуулийн 54.5 заасан бүрэлдэхүүнээр тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4.5 "санхүүгийн тайлангийн тодруулга", 54.5.1 "тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл", 54.5.4 "хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга", 54.5.5. "нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга" гэж тус тус заасантай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг батлагдсан маягтын дагуу, тодруулга тайлбар тэмдэглэл, хөтөлбөр арга хэмжээ, хүрсэн үр дүн танилцуулгын хамт бэлтгэж байх.

2. Зардлын эдийн засгийн ангилал зөрүүлж бичиг хэргээс гарын үсгийн баталгааны төлбөрт 20.0 мянган төгрөг, шуудан холбооны зардлаас цэвэр, бохир усны төлбөрт 233.1 мянган төгрөг, БҮТЭЗ-ийн зардлаас зарын төлбөрт 885.0 мянган төгрөг, урсгал засварын зардлаас хөрөнгийн үнэлгээний төлбөрт 188.6 мянган төгрөг, уртасгагч залгуур, даралтын аппарат баталгаажуулсны төлбөрт 205.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас бичиг хэргийн зардалд 175.8 мянган төгрөг, нийт 1,707.8 мянган төгрөгийг зардлын ангилал зөрчиж зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан ангиллын "тавдугаар хавсралт"-д тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулахгүй байх.

3. Тус төвийн захирлын 2025 оны А/01 дугаар тушаалаар ажиллагсдын үндсэн цалинг шинэчлэн тогтоохдоо Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоол, 2024 оны 238 дугаар тогтоолыг үндэслэсэн боловч ажиллагсдын цалинг 10-20 хувиар нэмэгдүүлсэн, архив бичиг хэргийн эрхлэгчийн цалингийн шатлалыг буруу тогтоосон, Захирлын 2025 оны А/12 дугаар тушаалаар 2 ажилтанд ур чадварын нэмэгдлийг 10-15 хувиар бууруулан олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.14. "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно". Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт 2. "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч шийдвэрлэнэ"-д тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тус төвийн албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэлийг зөв тогтоох, төсөв захирагчийн гаргасан шийдвэрийг хэрэгжүүлдэг байх.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ****Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
1.	Петростар ХХК-д түлш шатахууны зардлаас 3,019.7 мянган төгрөг шилжүүлж, тохируулах бичилтээр шууд зардалд бүртгэсэн.	1	3,019.7			1	3,019.7	1	3,019.7				
2.	Бараа материалын дансны үлдэгдлийг 30.1 мянган төгрөгөөр дутуу, 538.2 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;	1	568.3			1	568.3	1	568.3				
3.	Акталсан үлдэх өртөгтэй 360.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассаны гарзыг тайлант үеийн элэгдлийн зардлаар бүртгэсэн.	1	436.8			1	436.8	1	436.8				
4.	Байгууллагад төлөх өглөгийг 2,772.0 мянган төгрөгөөр, хувь хүмүүст төлөх өглөгийг 120.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан	1	2,892.0			1	2,892.0	1	2,892.0				
5.	Тайлант үеийн үр дүнг 577.2 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.	1	577.2			1	577.2	1	577.2				
6.	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих дүнг 120.0 мянган төгрөгөөр дутуу, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий орлогыг 5,772.0 мянган төгрөгөөр илүү, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын хандив 79,769.0 мянган төгрөгийг эдийн засгийн ангилал зөрүүлж, тайлагнасан	1	85,541.0			1	85,541.0	1	85,541.0				
7.	Үр дүнгийн тайланд Зардлын эдийн засгийн ангилалыг 6,085.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;	1	6,085.6			1	6,085.6	1	6,085.6				
8.	Мөнгөн гүйлгээний тайланд туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих дүнг	1	2,994.0			1	2,994.0	1	2,994.0				

	2,994.0 мянган төгрөгөөр дутуу, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг 2,994.0 мянган төгрөгөөр илүү тусгасан.												
	<b>Дүн</b>	<b>8</b>	<b>102,114.6</b>			<b>8</b>	<b>102,114.6</b>	<b>8</b>	<b>102,114.6</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1.	2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу тодруулга болон төсвийн тухай хуулийн 54.5 заасан бүрэлдэхүүнээр тайлагнаагүй байна.	1	-							1	-				
2.	Тус төвийн захирлын 2025 оны А/01 дугаар тушаалаар ажиллагсдын үндсэн цалинг шинэчлэн тогтоохдоо Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоол, 2024 оны 238 дугаар тогтоолыг үндэслэсэн боловч ажиллагсдын цалинг 10-20 хувиар нэмэгдүүлэн, архив бичиг хэргийн эрхлэгчийн цалингийн шатлалыг буруу тогтоосон, Захирлын 2025	1	-							1	-				

	оны А/12 дугаар тушаалаар 2 ажилтанд ур чадварын нэмэгдлийг 10-15 хувиар бууруулан олгосон байна.												
3.	Бусад хангамжийн материалын тайлангийн орлого, зарлагын гарын үсгийн бүрдэл дутуу хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар 65,446.9 мянган төгрөг, эмийн тайлангийн баримтыг хянаж, зөвшөөрсөн эмнэлгийн тусламж, үйлчилгээний албаны даргын зөвшөөрөлгүй, эмчлүүлэгчийн хэрэглэсэн эмийн жагсаалтыг хавсаргаагүй 16,563.0 мянган төгрөгийн анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.	1	82,009.9			1	82,009.9						
4.	Хөрөнгийн үнэлгээний төлбөр 188.6 мянган төгрөгийг ДАМНО ХХК-д анхан шатны нотлох баримтгүй шилжүүлсэн байна	1	188.6	1	188.6								
5.	Тус төвийн захирлын 2025 оны А/33 дүгээр тушаалаар сахилгын шийтгэл ногдуулж, сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад эдийн засагчид үр дүнгийн мөнгөн урамшуулалд 2,720.2 төгрөг олгосон байна.	1	2,720.2	1	2,720.2								
6.	Тус төвийн захирал нь хот дотор албан тушаалын суудлын автомашин хэрэглэж 773.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулж, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй. Мөн анхан шатны	1	1,455.9	1	1,455.9								

	баримтгүй 682.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.											
7.	Тус төвийн захирлын 2025 оны А/34 дүгээр тушаалаар ахлах нягтлан бодогчид цалинг 3 сарын хугацаатай 20 хувь бууруулах сахилгын шийтгэл оногдуулсны 1,081.2 мянган төгрөг, сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад 2 дугаар улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалд 361.7 мянган төгрөг тус тус олгосон байна.	1	1,442.9			1	1,442.9					
8	Зардлын эдийн засгийн ангилал зөрүүлж бичиг хэргээс гарын үсгийн баталгааны төлбөрт 20.0 мянган төгрөг, шуудан холбооны зардлаас цэвэр, бохир усны төлбөрт 233.1 мянган төгрөг, БҮТЭЗ-ийн зардлаас зарын төлбөрт 885.0 мянган төгрөг, урсгал засварын зардлаас хөрөнгийн үнэлгээний төлбөрт 188.6 мянган төгрөг, уртасгагч залгуур, даралтын аппарат баталгаажуулсны төлбөрт 205.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас бичиг хэргийн зардалд 175.8 мянган төгрөг, нийт 1,707.8 мянган төгрөгийг зардлын ангилал зөрчиж зарцуулсан байна.	1	1,707.8					1	1,707.8			
	<b>Дүн</b>	<b>8</b>	<b>89,525.3</b>	<b>3</b>	<b>4,364.7</b>	<b>2</b>	<b>83,452.8</b>	<b>3</b>	<b>1,707.8</b>			

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Хариуцлага тооцуулах албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
1.	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих 139 мэдээллээс 47 мэдээллийг хугацаа 47 хоцроож байршуулсан, таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 391,954.4 мянган төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй, Тус байгууллагын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хуульд заасан хугацаанаас 8 хоногоор хоцроож аудитын байгууллагад ирүүлсэн байна	1	391,954.4	1	391,954.4		
	<b>Дүн</b>	1	391,954.4	1	391,954.4		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 111/20150185

Улаанбаатар хот

СМГ-2026/68/НА-СТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Геронтологийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус төвийн захирлын 2025 оны А/33 дүгээр тушаалаар сахилгын шийтгэл ногдуулж, сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад эдийн засагч Д.Гунгаажав-т 2, 3, 4 дүгээр улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалд 2,720,160.00 /хоёр сая долоон зуун хорин мянга нэг зуун жаран/ төгрөг олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-д "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.7-д "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"-д заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй байхад мөнгөн урамшуулалд олгосон 2,720,160.00 /хоёр сая долоон зуун хорин мянга нэг зуун жаран/ төгрөгийг эдийн засагч Д.Гунгаажав-аар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
- Төлбөрийн актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Геронтологийн үндэсний төвийн захирал /Д.Бат-Ундрах/, Санхүү, дэмжих үйлчилгээний албаны дарга, ахлах нягтлан бодогч /Г.Батболд/ нарт хариуцуулав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

АКТ ТОГТООСОН:  
  
9206107  
ATA1097  
9025981411

Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
Н.ЦЭРЭНХАНД



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 110/00150185

Улаанбаатар хот

СНТ-0026/68/МА-СТТ-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Геронтологийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөрөнгийн үнэлгээний төлбөр 188,600.00 /нэг зуун наян найман мянга зургаан зуун/ төгрөгийг ДАМНО ХХК-д анхан шатны нотлох баримтгүй шилжүүлсэн байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.1-д "Төрийн өмч хөрөнгийг үндэслэлгүйгээр бусдад хандивласан, үнэ төлбөргүй шилжүүлсэн" гэсэн заалтын үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хөрөнгийн үнэлгээний төлбөрийн 188,600.00 /нэг зуун наян найман мянга зургаан зуун/ төгрөгийг ДАМНО ХХК-аар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Төлбөрийн актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Геронтологийн үндэсний төвийн захирал /Д.Бат-Ундрах/, Санхүү, дэмжих үйлчилгээний албаны дарга, ахлах нягтлан бодогч /Г.Батболд/ нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ

Н.ЦЭРЭНХАНД



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 109/А0150185

Улаанбаатар хот

САН-2026/68/НА-СТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Геронтологийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус төвийн захирал нь 2025 оны эхний 6 сард хот дотор албан тушаалын суудлын автомашин хэрэглэж 773,370.00 /Долоон зуун далан гурван мянга гурван зуун далан/ төгрөгийн шатахуун зарцуулж өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй. Мөн анхан шатны баримтгүй 682,597.00 /зургаан зуун наян хоёр мянга таван зуун ерэн долоон/ төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.1."Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д " бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Тус төвийн захирлаар ажиллаж байсан Р.Хишигжаргалаар 1,455,967.00 /нэг сая дөрвөн зуун тавин таван мянга есөн зуун жаран долоон/ төгрөгийг төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Төлбөрийн актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Геронтологийн үндэсний төвийн захирал /Д.Бат-Ундрах/, Санхүү, дэмжих үйлчилгээний албаны дарга, ахлах нягтлан бодогч /Г.Батболд/ нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

*[Handwritten signature]*  
*[Handwritten signature]*  
*[Handwritten signature]*

Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
Н.ЦЭРЭНХАНД

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Akt\2026\0225 SAG-65.Docx

1526200086



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 504/20150169

Улаанбаатар хот

САН-2026/68/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Геронтологийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бусад хангамжийн материалын тайлангийн орлого, зарлагын гарын үсгийн бүрдэл дутуу хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар 65,446,900.00 /жаран таван сая дөрвөн зуун дөчин зургаан мянга есөн зуу/ төгрөг, эмийн зарлагын баримтыг хянаж, зөвшөөрсөн эмнэлгийн тусламж, үйлчилгээний албаны даргын зөвшөөрөлгүй, эмчлүүлэгчийн хэрэглэсэн эмийн жагсаалт үйлдээгүй 16,563,000.00 /арван зургаан сая таван зуун жаран гурван мянган/ төгрөг, нийт 82,009,900.00 /наян хоёр сая есөн мянга есөн зуун/ төгрөгийн анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж тус тус заасантай нийцээгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Геронтологийн үндэсний төвийн захирал /Д.Бат-Ундрах/, санхүү дэмжих үйлчилгээний албаны дарга, ахлах нягтлан бодогч/Г.Батболд/нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
Ц.ЭРЭНХАНД



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-99.Docx

1526181125



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 525/00150169

Улаанбаатар хот

САН-2026/68/МБ-СТЭ-ТМЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Геронтологийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих 139 мэдээллээс 47 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 391,954,400.00 /гурван зуун ерэн нэгэн сая есөн зуун тавин дөрвөн мянга дөрвөн зуун/ төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй.

Мөн тус байгууллагын санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанаас 8 хоногоор хоцроож аудитын байгууллагад ирүүлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-д "төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:


Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-99.Docx

1526181120

1. Шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулбал зохих мэдээллийг байршуулаагүй болон хугацаа хоцроож байршуулсан, өмнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайланг хуулийн хугацаанд ирүүлээгүй зэрэг зөрчил гаргасан Санхүү, дэмжих үйлчилгээний албаны дарга Г.Батболд-д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Геронтологийн үндэсний төвийн захирал/Д.Бат-Ундрах/-д хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
Н.ЦЭРЭНХАНД



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 526/20150169

Улаанбаатар хот

СОГ-2026/68)чА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Геронтологийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус төвийн захирлын 2025 оны А/34 дүгээр тушаалаар ахлах нягтлан бодогч Д.Янжмаад цалинг 3 сарын хугацаатай 20.0 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсны 1,081,200.00 /нэг сая наян нэгэн мянга хоёр зуун/ төгрөгийн сахилгын шийтгэлийг суутгаагүй, сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад 2 дугаар улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалд 361,688.00 /гурван зуун жаран нэгэн мянга зургаан зуун наян найман/ төгрөгийг тус тус олгосон байна.

Энэ нь Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.1-д "Ажиллагсад хөдөлмөрийн гэрээ буюу албан тушаалын дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ бусдад учруулсан гэм хорын хариуцлагыг түүнийг ажиллуулж байгаа ажил олгогч хүлээнэ", Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1-д "Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно", 119.1.3-т "ажилтанд энэ хуулийн 123.2.3-т заасан хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулсан", мөн хуулийн 123 дугаар зүйлийн 123.8 "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралтаар баталсан", Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.7-д "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлдэггүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сахилгын шийтгэлийг бүрэн суутгаагүй 1,081,200.00 /нэг сая наян нэгэн мянга хоёр зуун/ төгрөг, сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй байхад урамшуулалд олгосон 361,688.00 /гурван зуун жаран нэгэн мянга зургаан зуун наян найман/ төгрөг, нийт 1,442,888.00 /нэг сая дөрвөн зуун дөчин хоёр мянга найман зуун наян найман/ төгрөгийн байгууллагад учирсан хохирлыг ахлах нягтлан бодогч Д.Янжмаагаар төлүүлэхээр Иргэний хэргийн журмаар шүүхэд хандан шийдвэрлүүлж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Геронтологийн үндэсний төвийн захирал /Д.Бат-Ундрах/, санхүү дэмжих үйлчилгээний албаны дарга, ахлах нягтлан бодогч /Г.Батболд/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

